



**ОРХОН АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2019 оны 01 сарын 22 өдөр

Дугаар 06

Эрдэнэт

Ээлжит хуралдаан зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 23 дугаар зүйлийн 23.4 дэх заалт, аймгийн Засаг даргын саналыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 7 дахь удаагийн сонгуулийн Ээлжит XIII хуралдааныг 2019 оны 02 дугаар сарын 22-ны өдөр Эрдэнэт хотод зарлан хуралдуулж, дараах асуудал хэлэлцүүлэхээр тогтоосугай.

- 1.1.Тогтвортой ногоон хөгжлийн бодлого батлах тухай
- 1.2.Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын үнийг шинэчлэн батлах тухай
- 1.3.Нийтийн тээврийн үйлчилгээний үнэ тарифт индексжүүлэлт хийх тухай
- 1.4.Даваат, Уртын гол, Яргуйт багуудын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө батлах тухай
- 1.5.Өрхийн жижиг үйлдвэрлэлийг дэмжих зээлийн сан байгуулах тухай
- 1.6.Орон нутгийн төсвийн болон Эрдэнэт сангийн 2018 оны шилжих үлдэгдлээс зарцуулах хөрөнгийн жагсаалт батлах тухай

Хоёр.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит XIII хуралдааны бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

Гурав.Хуралдааны бэлтгэл хангаж хуралдуулахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга П.Пүрэвлхагвад даалгасугай.

ДАРГА



П.ПҮРЭВЛХАГВА